



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар A/62

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улс дахь Оросын Холбооны Улсын өмчийн маргаантай асуудлыг шийдвэрлэх хоёр дахь шатны ажлын жагсаалтад орсон Улаанбаатар хот дахь газар, үл хөдлөх хөрөнгийн талаар үзлэг хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Монголын талын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч: Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн /зөвшилцсөнөөр/

Гишүүд: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн М.Баярмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Р.Ширчинням

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч Б.Одонгэрэл /зөвшилцсөнөөр/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Мэдээлэл, технологийн албаны ажилтан Т.Мөнхбаяр

2. Ажлын хэсгийн удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.


3. Удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 14-ний өдөрт багтаан хийж гүйцэтгэн, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (П.Баянтүмэн)-т үүрэг болгосугай.

ТӨБЗГ тушаал-/2022

**132013301**

4.Газар, үл хөдлөх хөрөнгийг үзэж, танилцахад зориулж ажлын хэсгийг автомашинаар хангаж, шатахуун зарцуулахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Н.Ганболд), Ерөнхий нягтлан бодогч (Ц.Гантуяа)-д хоёрдугаар хавсралтаар зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 10 дугаар сарын 12 өдрийн  
2/62 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Оросын Холбооны Улсын өмчийн хоёр дахь шатны объектын жагсаалтад орсон газар талбайн хамтарсан үзлэг шалгалтыг зохион байгуулах, үл хөдлөх хөрөнгийн акт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ОХУ-ын талын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. ОХУ-ын эдэлбэр газар дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн бодит байдалд үзлэг шалгалт хийж акт үйлдэж баталгаажуулна. /фото зураг, видео бичлэг хийх/

2. Эдэлбэр газарт хэмжилт хийж, кадастрын зургийн тулгалт хийх, маргаан гарсан тохиолдолд эргэлтийн цэгийн хэмжилт хийнэ.

3. Үзлэг шалгалтын тайланг бэлтгэж хамтарсан Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахад бэлтгэнэ.

-----000-----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн  
А/62 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

/төгрөгөөр/

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажиллах хүний тоо	Ажиллах хоног /календарь/	автомашин /шатахуун/	Нийт зардал
		Нэр	Албан тушаал				
1	Улаанбаатар	М.Баярмаа, Р.Ширчинням, Т.Мөнхбаяр	Мэргэжилтэн	4	3	100,000.00	300,000.00
Нийт зардал						100,000.00 (нэг зуун мянган)	300,000.00 (гурван зуун мянган)